



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/548

Ховд

Өөрийн аймгаас бусад аймаг, сумдад өвс худалдан
борлуулахыг хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалтын А хэсэг, Монгол Улсын Засгийн газрын Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2020 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтанд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аймаг, сумдын өвсний нөөцийг бүрдүүлэх, үнийн хөөрөгдлийг бууруулах зорилгоор бусад аймаг, сумдад өвс худалдан борлуулахыг 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн хориглосугай.

2. Хадлангийн бүс нутгаас бэлтгэсэн өвсийг өөр аймаг, сумдад худалдан борлуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, өвсийг гадагш тээвэрлүүлэхгүй байх, худалдан борлуулахыг завдсан иргэн, аж ахуйн нэгжид хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/ -т, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ